

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3 Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
3.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	9
3.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
4. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ
ТӨСЛИЙН ЗАХИРАЛ
М САНЖААДОРЖ ТАНАА

2020.04.07 № 06/1087
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн захирал М.Санжаадорж Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн цалин хөдөлмөрийн хөлсний тооцоолол тайлагналыг үнэн зөв хийх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дугаар сарын 02-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Мүүрь Аудит ХХК-ийн баталгаажуулах үйлчилгээний менежер П.Нарантуяа ахлагчтай баг хариуцаж хэрэгжүүлэв.

“Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн 2019 оны санхүүгийн тайланг 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн албан бичгээр, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Мүүрь Аудит ХХК-д тус тус ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь уул уурхайн болон боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих дэд бүтцэд санхүүжилтийн эх үүсвэрээс үл хамааран хөрөнгө оруулалт хийхийг дэмжих, дэд бүтцийн төслүүдийг боловсруулж хэрэгжүүлэх дотоодын чадавхыг нэмэгдүүлэхэд оршино.

“Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих;
- Чадавхыг бэхжүүлэх, мэдлэг шилжүүлэх;
- Гүний усны менежментийг бэхжүүлэх зэрэг байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулийн нийгмийн даатгалын хувь хэмжээ;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос хөнгөлөх албан татварын хөнгөлөлтийн хэмжээ өөрчлөгдсөн байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн мөрдөж байгаа Санхүүгийн удирдлагын гарын авлага нь Дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн гарын авлага, холбогдох дүрэм журамтай нийцсэн байна.

“Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Инфо системс программ хангамж ашигладаг байна.

“Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөө сул байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 6 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 4,776,172.9 мянган төгрөгөөс тооцон 47,761.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин өөрчлөгдөөгүй.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 5,885,774.8 мянган төгрөгөөр буюу 69.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, засгийн газрын оролцооны дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,239,371.4	2,378,921.0	(5,860,450.4)
Авлага	180.6	-	(180.6)
Урьдчилгаа			
Бараа материал			
Үндсэн хөрөнгө	216,074.0	190,131.4	(25,942.5)
Нийт хөрөнгө	8,455,625.9	2,569,052.4	(5,886,573.5)
Өр төлбөр	1,062.3	263.6	(798.7)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8,454,563.6	2,568,788.8	(5,885,774.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,455,625.9	2,569,052.4	(5,886,573.5)

Төсөл нь нөхөн дүүргэлтийн зарчмаар санхүүжилт авдаг. Төслийн үйл ажиллагаа тайлант оны эцсээр тасалбар болон дуусаж байгаа учраас мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс төслийн үйл ажиллагааг санхүүжүүлсэн. Тиймээс тайлант хугацааны эцэст төслийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалсан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,568,788.8 мянган төгрөг болж 5,886,774.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь тайлант оны санхүүжилтээс үйл ажиллагааны зардлын дүн өндөр байсантай холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт зориулан 4,535,000.0 мянган төгрөгийн төсвийг төсөл, хөтөлбөрийн зардалд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 4,535,000.0 мянган төгрөгийг гадаад эх үүсвэрийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гадаад эх үүсвэрээс санхүүжих орлого 4,076,101.2 мянган төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь төслийн үйл ажиллагаа дуусаж Дэлхийн банкны санхүүжилт буурснаас шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,614,005.7 мянган төгрөг буюу 102 хувьтай байгаа нь төслийн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагаа нь тайлант хугацаанд гүйцэтгэгдсэн болохыг харуулж байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2,524,562.8 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрснээс 2,492,805.6 мянган төгрөгийн 8 алдааг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд залруулж, 31,757.2 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчилд албан шаардлага өглөө.

Бүртгэл тайлагналтай холбоотой 2,492,805.6 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- ХХОАТ-ын өглөгийг 263.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийг 1,601.0 мянган төгрөгөөр илүү тооцож, тайлагнасан;
- Хүүгийн орлогыг 2,528.4 мянган төгрөгөөр дутуу бүртгэж тайлагнасан;
- Хүүгийн орлогоос төвлөрүүлсэн 2,528.4 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг бүртгэж, тайлагнаагүй;
- Сургалтад зарцуулсан 3,672.0 мянган төгрөгийн зарцуулалтыг санхүүгийн тайланд буруу толилуулсан;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлт хэлбэрээр олгогдсон 399,482.5 мянган төгрөгийн орлого, зардал, үндсэн хөрөнгийг дутуу тайлагнасан;
- Тайлант хугацаанд зээлдэгч болон хандивлагчид буцаан шилжүүлсэн 1,969,029.0 мянган төгрөгийн санхүүжилтийн төлбөрийг санхүүгийн тайланд буруу толилуулсан;
- Гадаад валютаарх мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэлд тооцсон ханшийн тэгшитгэлийн олзыг нягтлан бодох бүртгэлд 113,700.7 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн.

Аудитаар 31,757.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Эд хариуцагч солигдоход болон жилийн эцэст хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгийг зохих зөвшөөрөлгүй өөр төсөлд ашиглуулсан, хадгалалт хамгаалалт, хяналт хангалтгүй. Үндсэн хөрөнгийн хяналтын тооллого хийхэд нийт 378.0 мянган төгрөгийн өртөг бүхий 2 ширхэг зөөврийн хатуу диск бодитоор байхгүй, 27,707.2 мянган төгрөгийн хөрөнгө бодитоор оршин байгаа эсэхийг нотлох боломжгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 12.2.2.эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед;” гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тушаал шийдвэргүйгээр харилцах дансны үлдэгдэлд бодогдсон хүүгийн орлогоос сургалтын зардалд 3,672.0 мянган төгрөг зарцуулсан нь Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.1.11 “Сангийн яам нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд: гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол төслийн тусгай болон дэд дансны хүүгийн орлогыг захиран зарцуулах шийдвэр гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төсөл хэрэгжүүлэх хугацаа тайлант хугацаагаар тасалбар болон дуусаж байгаа учраас дараагийн аудит хийгдэхгүй болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 8 мэдээллийг бүрэн байршуулсан, 5 мэдээллийг дутуу, 4 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

2018 оны санхүүгийн тайланд Од Бүртгэл Аудит ХХК-иас хийсэн аудитаар үндсэн хөрөнгө, зардал, засгийн газрын санхүүжилтийн талаарх 3 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 33.3 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 31,757.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 47,761.7 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,239,371,391.53	2,378,920,975.96
31110	Кассад байгаа бэлэн мөнгө	2,084.55	-
3121	Банканд байгаа бэлэн мөнгө (төгрөгөөр)	17,244,949.12	5,995,371.57
3122	Банканд байгаа бэлэн мөнгө (гадаад валютаар)	8,222,124,357.86	2,372,925,604.39
	АВЛАГА	180,556.20	-
335	Бусад авлага	180,556.20	-
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,239,551,947.73	2,378,920,975.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	216,073,995.40	190,131,438.03
392	Биет хөрөнгө	213,688,994.94	189,336,437.79
	Авто тээврийн хэрэгсэл	168,055,555.56	127,722,222.22
39203	Авто тээврийн хэрэгсэл	314,326,906.30	314,326,906.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	(146,271,350.74)	(186,604,684.08)
	Машин тоног төхөөрөмж /компьютер/	31,859,545.99	50,999,704.86
39205	Машин тоног төхөөрөмж /компьютер/	94,547,120.24	133,004,073.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	(62,687,574.25)	(82,004,368.66)
	Тавилга аж ахуйн эд хогшил	13,773,893.40	10,614,510.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,751,126.82	31,751,126.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,977,233.42)	(21,136,616.11)
393	Биет бус хөрөнгө	2,385,000.45	795,000.24
	Программ хангамж	2,385,000.45	795,000.24
39301	Программ хангамж	13,580,400.88	13,580,400.88
39302	Хуримтлагдсан элэгдэл	(11,195,400.43)	(12,785,400.64)
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	216,073,995.40	190,131,438.03
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,455,625,943.13	2,569,052,413.99
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,062,340.20	-
41363	ХХОАТ-ын өглөг	-	263,600.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,062,340.20	263,600.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,062,340.20	263,600.00
51	Засгийн газрын хувь оролцоо	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	8,454,563,602.94	2,568,788,813.99
51210	Өмнөх үеийн үр дүн	10,152,265,832.36	8,454,563,602.94
51220	Тайлант үеийн үр дүн	(1,697,702,229.42)	(5,885,774,788.95)
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	8,454,563,602.94	2,568,788,813.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	8,455,625,943.13	2,569,052,413.99

3.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,778,194,022.77	625,173,249.81
120	Нийтлэг татварын бус орлого	214,020,040.32	166,274,495.55
120002	Хүүгийн орлого	214,020,040.32	165,524,495.55
120009	Бусад орлого	-	750,000.00
122	Тусламжийн орлого	546,870,908.95	402,513,998.56
122002	Тусламжийн орлого	546,870,908.95	402,513,998.56
124	Зээлийн орлого	2,017,303,073.50	56,384,755.70
124001	Зээлийн хөрөнгөөр санхүүжсэн орлого	2,017,303,073.50	56,384,755.70
	Засгийн газрын санхүүжилт	12,752,585.77	518,804,192.53
	Засгийн газрын санхүүжилт (НӨАТ-ын чөлөөлөлт)	12,752,585.77	518,804,192.53
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,790,946,608.54	1,143,977,442.34
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,263,736,640.99	7,143,452,951.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,263,736,640.99	5,161,806,202.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	294,136,200.00	-
210101	Цалин	294,136,200.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,296,344.00	-
210201	Тэтгэврийн даатгал	23,530,896.00	-
210202	Тэтгэмжийн даатгал	2,941,362.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,353,089.60	-
210204	Ажилгүйдлийн даатгал	588,272.40	-
210205	Эрүүл мэндийн даатгал	5,882,724.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,877,979.00	32,985,000.00
210304	Байрны түрээсийн зардал	43,877,979.00	32,985,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,061,993.81	16,317,179.11
210401	Бичиг хэргийн материал	21,302,927.35	3,829,636.37
210402	Тээвэр, шатахууны зардал	35,199,097.93	7,967,818.18
210403	Шуудан холбооны зардал	9,559,968.53	4,519,724.56
2107	Томилолт, зочны зардал	200,236,163.05	21,613,840.00
210702	Дотоод томилолтын зардал	200,236,163.05	21,613,840.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,315,085,897.85	5,024,088,320.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,248,846,467.31	5,020,416,350.51
210808	Банкны үйлчилгээний хураамж	1,101,137.67	-
210813	Бусад	65,138,292.87	3,671,970.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	309,042,063.28	66,801,862.65
210901	Бараа, үйлчилгээний бусад зардал	-	2,402,352.00
210903	Элэгдлийн зардал	309,042,063.28	64,399,510.65
213	Урсгал шилжүүлэг	-	1,981,646,749.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг (Сангийн яам)	-	12,617,804.40
213505	Төвлөрүүлэх шилжүүлэг (Дэлхийн банк)	-	1,969,028,944.65
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	2,263,736,640.99	7,143,452,951.32

	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	527,209,967.55	(5,999,475,508.98)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз	629,552,443.56	113,700,720.03
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	629,552,443.56	113,700,720.03
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
225001	Хөрөнгө данснаас хассаны гарз	2,854,464,640.53	-
225004	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз	-	-
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	2,854,464,640.53	-
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(1,697,702,229.42)	(5,885,774,788.95)

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Данс-ны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,777,870,180.53	625,173,249.81
120	Нийтлэг татварын бус орлого	214,020,040.32	166,274,495.55
120002	Хүүгийн орлого	214,020,040.32	165,524,495.55
120009	Бусад орлого	-	750,000.00
122	Тусламжийн орлого	546,617,907.20	402,513,998.56
122002	Тусламжийн орлого	546,617,907.20	402,513,998.56
124	Зээлийн орлого	2,017,232,233.01	56,384,755.70
124001	Зээлийн хөрөнгөөр санхүүжсэн орлого	2,017,232,233.01	56,384,755.70
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,777,870,180.53	625,173,249.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,940,736,365.71	6,564,363,518.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,940,736,365.71	4,582,716,769.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	294,136,200.00	-
210101	Цалин	294,136,200.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,296,344.00	-
210201	Тэтгэврийн даатгал	23,530,896.00	-
210202	Тэтгэмжийн даатгал	2,941,362.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,353,089.60	-
210204	Ажилгүйдлийн даатгал	588,272.40	-
210205	Эрүүл мэндийн даатгал	5,882,724.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,220,479.00	32,985,000.00
210304	Байрны түрээсийн зардал	40,220,479.00	32,985,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	63,281,418.04	16,317,179.11
210401	Бичиг хэргийн материал	20,536,304.44	3,829,636.37
210402	Тээвэр, шатахууны зардал	33,805,516.09	7,967,818.18
210403	Шуудан холбооны зардал	8,939,597.51	4,519,724.56
2107	Томилолт, зочны зардал	200,236,163.05	21,613,840.00
210702	Дотоод томилолтын зардал	200,236,163.05	21,613,840.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,296,000,307.08	4,509,398,398.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,230,084,718.77	4,505,726,428.63
210808	Банкны үйлчилгээний хураамж	777,295.44	-
210813	Бусад	65,138,292.87	3,671,970.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,565,454.54	2,402,352.00
210901	Бусад бараа үйлчилгээний зардал	11,565,454.54	2,402,352.00
213	Урсгал шилжүүлэг	-	1,981,646,749.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг (Сангийн яам)	-	12,617,804.40
213505	Төвлөрүүлэх шилжүүлэг (Дэлхийн банк)	-	1,969,028,944.65
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	1,940,736,365.71	6,564,363,518.79
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	837,133,814.82	(5,939,190,268.98)
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-

	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
225101	Үндсэн хөрөнгө худалдан авах зардал	-	34,960,866.62
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)	-	34,960,866.62
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨН/ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(34,960,866.62)
	САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
145006	Авсан зээл	-	-
240001	Төлсөн зээл	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨН/ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)	-	-
250001	Валютын ханшийн зөрүү	629,552,443.56	113,700,720.03
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)	1,466,686,258.39	(5,860,450,415.57)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,772,685,133.14	8,239,371,391.53
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,239,371,391.53	2,378,920,975.96

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл		10,152,265,832.36	10,152,265,832.36
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-	-
Залруулсан үлдэгдэл	-	10,152,265,832.36	10,152,265,832.36
Тайлант үеийн үр дүн		(1,697,702,229.42)	(1,697,702,229.42)
2018 оны 12-р сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл	-	8,454,563,602.94	8,454,563,602.94
Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт		-	-
Залруулсан үлдэгдэл	-	8,454,563,602.94	8,454,563,602.94
Тайлант үеийн үр дүн		(5,885,774,788.95)	(5,885,774,788.95)
2019 оны 12-р сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл	-	2,568,788,813.99	2,568,788,813.99

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,535,000,000.00	4,614,005,666.36	(79,005,666.36)	(2)
УРСГАЛ ЗАРЛАГА	4,535,000,000.00	4,614,005,666.36	(79,005,666.36)	(2)
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,535,000,000.00	4,614,005,666.36	(79,005,666.36)	109
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,740,000.00	32,985,000.00	11,755,000.00	26
Байрны түрээс	44,740,000.00	32,985,000.00	11,755,000.00	26
Хангамж бараа материалын зардал	20,160,000.00	16,317,179.11	3,842,820.89	19
Бичиг хэрэг	5,000,000.00	3,829,636.37	1,170,363.63	23
Тээвэр, шатахуун	9,160,000.00	7,967,818.18	1,192,181.82	13
Шуудан, холбоо интернэтийн төлбөр	6,000,000.00	4,519,724.56	1,480,275.44	25
Томилолт, зочны зардал	25,000,000.00	21,613,840.00	3,386,160.00	14
Дотоод албан томилолт	25,000,000.00	21,613,840.00	3,386,160.00	14
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	4,440,100,000.00	4,540,687,295.25	(100,587,295.25)	(2)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,440,100,000.00	4,540,687,295.25	(100,587,295.25)	(2)
Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	2,402,352.00	2,597,648.00	52
Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	2,402,352.00	2,597,648.00	52
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР				
НИЙТ ОРЛОГО	4,535,000,000.00	458,898,754.26	4,076,101,245.74	90
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	4,535,000,000.00	458,898,754.26	4,076,101,245.74	90
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	0
Төсвөөс гадуур байгууллага	1	1	-	0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	6	6	-	0
Удирдах ажилтан	1	1	-	0
Гүйцэтгэх ажилтан	5	5	-	0
Үйлчлэх ажилтан	-	-	-	-
Гэрээт ажилтан	-	-	-	-

4. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020.03.30			САГ-2020/706/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төслийн жилийн эцсийн тайлан бэлтгэхэд хөрөнгийн тооллого хийгээгүй. Төслийн хөрөнгийг зохих зөвшөөрөлгүйгээр өөр төсөлд ашиглуулж байгаа. Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, хяналт сул. Үндсэн хөрөнгөнд хяналтын тооллогын горим хэрэгжүүлэхэд нийт 378.0 мянган төгрөгийн анхны өртөг бүхий 2 ширхэг зөөврийн хатуу диск бодитоор оршин байгаагүй. Мөн 27,707.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бодитоор оршин байгаа эсэхийг нотлох боломжгүй байна.	28,085.2	Албан шаардлага өгөх	Төслийн захирал Санхүүгийн ажилтан	М.Санжаадорж Б. Ундармаа
2	Хүүгийн орлогоос сургалтын зардалд 3,672.0 мянган төгрөгийг төсвийн төвлөрүүлэн захирагчийн тушаал, шийдвэргүйгээр зарцуулсан.	3,672.0	Албан шаардлага өгөх	Төслийн захирал Санхүүгийн ажилтан	М.Санжаадорж Б. Ундармаа
	Нийт	31,757.2			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25

№ 02/199

Улаанбаатар хот

Сэт 2020/706/СТА-ТХ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тушаал шийдвэргүйгээр харилцах дансны үлдэгдэлд бодогдсон хүүгийн орлогоос сургалтын зардалд 3,672.0 мянган төгрөг зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.1.11 “Сангийн яам нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд: гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол төслийн тусгай болон дэд дансны хүүгийн орлогыг захиран зарцуулах шийдвэр гаргах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах, цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн зохицуулагч М.Санжаадорж, санхүүгийн удирдлагын мэргэжилтэн Б.Ундармаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
АХЛАХ АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:

“МҮҮРЬ АУДИТ” ХХК-ИЙН АУДИТОР
Ж.АРИУНАА

ЗӨВШӨӨРСӨН:

ТӨСЛИЙН ЗАХИРАЛ

М.САНЖААДОРЖ
САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН
МЭРГЭЖИЛТЭН

Б.УНДАРМАА

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25

№ 02/200

С.Р.Т. 80 20/706/СТА-ТХМ

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу "Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл"-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эд хариуцагч солигдоход болон жилийн эцэст хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгийг зохих зөвшөөрөлгүй өөр төсөлд ашиглуулсан, хадгалалт хамгаалалт, хяналт хангалтгүй. Үндсэн хөрөнгийн хяналтын тооллого хийхэд нийт 378.0 мянган төгрөгийн өртөг бүхий 2 ширхэг зөөврийн хатуу диск бодитоор байхгүй, 27,707.2 мянган төгрөгийн хөрөнгө бодитоор оршин байгаа эсэхийг нотлох боломжгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 12.2.2.эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах, эд хөрөнгө тооллого хийх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн зохицуулагч М.Санжаадорж, санхүүгийн удирдлагын мэргэжилтэн Б.Ундармаа нарт даалгав.

ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
АХЛАХ АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
"МҮҮРЬ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР
Ж.АРИУНАА

АЛБАН ШААРДЛАГЫГ

ЗӨВШӨӨРСӨН:
ТӨСЛИЙН ЗАХИРАЛ
М.САНЖААДОРЖ
САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН
МЭРГЭЖИЛТЭН
Б.УНДАРМАА

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

